

Засгийн газрын 2026 оны дугаар
сарын-ны өдрийн дүгээр
тогтоолын хавсралт

ЗӨВШӨӨРӨЛ, МЭДЭГДЛИЙН НЭГДСЭН САНГИЙН УДИРДЛАГА, ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Зөвшөөрөл, мэдэгдлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (цаашид “нэгдсэн сан” гэх)-г үүсгэж, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой мэдээллийг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид мэдээлэх, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн олгосон зөвшөөрөл, түүнд оруулсан өөрчлөлтийн шийдвэр, мэдэгдлийг нэгдсэн санд бүртгэж байршуулах, ашиглах, лавлагаа, мэдээллийг зөвшөөрөл, мэдэгдлийн цахим систем (license.mn)-ээр дамжуулан өгөхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Нэгдсэн санг бүрдүүлэх, цахим хуудсаар хөтлөх, мэдээллийг шинэчлэх, холбогдох лавлагаа мэдээлэл өгөхтэй холбоотой асуудлыг Зөвшөөрөл олгох болон Мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээд тус тус хариуцах бөгөөд нэгдсэн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, нээлттэй мэдээллийг нийтлэх, шинэчлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, (цаашид “яам”) хариуцан ажиллана. Нэгдсэн сангийн цахим систем, тэдгээрийн хэвийн үйл ажиллагаа, нэмэлт хөгжүүлэлт, техник хангамж, сүлжээний найдвартай, аюулгүй ажиллагааг "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" УТҮГ, (цаашид “хөгжүүлэгч”) хариуцна.

1.3.Нэгдсэн санг нэг талаас зөвшөөрөл хүсэгч иргэн хуулийн этгээд ДАН танилтын систем болон Нэвтрэлтийн нэгдсэн системээр нэвтэрч, нөгөө талаас зөвшөөрөл олгогч хуулийн этгээд төрийн үйлчилгээний нэгдсэн ХУР системийн мэдээлэлд тулгуурлан хуульд заасан зөвшөөрөл, мэдэгдлийн хүрээнд бүрдүүлэх бөгөөд тэдгээрт холбогдох хүсэлт, шийдвэр, олголт, өөрчлөлт, сунгалт, түдгэлзгэх, хүчингүй болгох, сэргээх, архивлах үйл явцыг зөвшөөрөл, мэдэгдлийн цахим системээр дамжуулан хөтөлнө.

Хоёр. Нэгдсэн сангийн бүтэц, мэдээлэл бүрдүүлэлт

2.1.Нэгдсэн санг үүсгэхдээ “Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо, кирилл болон монгол үсгийн нэгдсэн код “MNS 5552:2005” стандарт”-ыг дагаж мөрдөнө.

2.2.Нэгдсэн сан нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.1-д заасан “тусгай зөвшөөрөл”, 8.2-т заасан “энгийн зөвшөөрөл”-ийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгосон шийдвэрүүд болон 8.3-д заасан “мэдэгдэл”-ийн бүртгэлээс бүрдэнэ.

2.3.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчийн зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах хүсэлтийг зөвшөөрөл, мэдэгдлийн цахим системээр дамжуулан хүлээн авч, хариу мэдэгдлийг хүсэлт гаргагчид цахим хэлбэрээр илгээнэ.

2.4.Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигч нь зөвшөөрөл шинээр авах, сунгуулах болон мэдэгдлийн хүсэлт илгээхдээ системээс өгөгдөх зааврын дагуу зөвшөөрөл, мэдэгдлийн төрлийг сонгож, түүнд шаардагдах баримт бичгийг цахим хэлбэрээр хавсаргана.

2.5.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зөвшөөрлийг сунгахдаа тухайн зөвшөөрөлтэй холбоотой нэгдсэн санд байгаа мэдээллийг дахин шаардахгүй байна.

2.6.Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчийн хүсэлтийн түүх, явцын мэдээллийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь тухай бүр нэгдсэн санд илгээх бөгөөд зөвшөөрөл, мэдэгдэл хүсэгч, эзэмшигч нь өөрийн хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг зөвшөөрөл, мэдэгдлийн цахим системээс харах боломжтой байна.

2.7.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчийн хүсэлт болон холбогдох баримт бичиг хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, зөвшөөрөл олгох, сунгах, эсхүл зөвшөөрөл олгох, сунгахаас татгалзах шийдвэр гаргана. Зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэл, тайлбарыг Зөвшөөрлийн цахим системд оруулна.

2.8.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь зөвшөөрөл олгосон болон зөвшөөрөлд оруулсан өөрчлөлтийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 9-д заасны дагуу шийдвэр гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор нэгдсэн санд бүртгүүлнэ.

2.9.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд нь зөвшөөрөл олгосон болон зөвшөөрөлд оруулсан өөрчлөлтийг нэгдсэн санд бүртгэж, зөвшөөрөл олгосон болон түүнд оруулсан өөрчлөлтийн шийдвэрийн хамт эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

2.10.Эдийн засаг хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.9-д заасан нөхцөлийг ханган ирүүлсэн зөвшөөрөл олгосон болон зөвшөөрөлд оруулсан өөрчлөлтийг зөвшөөрлийн кодоор бүртгэлжүүлнэ.

2.11.Зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой үүсгэсэн мэдээллийн бүрэн, алдаагүй, үнэн зөв байдлыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд хариуцна.

2.12.Зөвшөөрөл эзэмшигч нь нэгдсэн санд орсон зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой мэдээллийг бүрэн бус, алдаатай гэж үзвэл залруулах хүсэлтийг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд гаргана.

2.13.Мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээд нь мэдэгдлийг нэгдсэн сангаас хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг хянан үзэж, дутуу эсхүл нөхөн бүрдүүлэх шаардлагатай баримт бичгийн талаар мэдэгдлээр үйл ажиллагаа эрхлэх этгээдэд Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан мэдэгдэнэ.

Гурав. Нэгдсэн санг эрхлэн хөтлөх, удирдлага, зохион байгуулалт

3.1.Нэгдсэн сан, зөвшөөрлийн цахим системийн үйл ажиллагаанд дараах оролцогч талууд байна.

3.1.1.нэгдсэн санг зөвшөөрлийн цахим системээр дамжуулан эрхлэн хөтлөх эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.1.2.нэгдсэн сан, зөвшөөрлийн цахим систем хөгжүүлэгч, техникийн үйлчилгээ үзүүлэгч;

3.1.3.зөвшөөрөл олгох, мэдэгдэл бүртгэх эрх бүхий этгээд;

3.1.4.зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигч;

3.1.5.зөвшөөрөл мэдэгдэл олгож буй үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий этгээд;

3.1.6.хуульд заасан үндэслэлээр нэгдсэн сангийн мэдээлэлтэй танилцах, лавлагааны мэдээлэл авах эрх бүхий этгээд.

3.2.Эдийн засаг хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг.

3.2.1.нэгдсэн санг цахимаар эрхлэн хөтөлж, түүний үйл ажиллагаа, мэдээлэл бүрдүүлэлт, ашиглалт, шинэчлэлт, мэдээллийн чанарт хяналт тавьж нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах;

3.2.2.нэгдсэн сангийн мэдээллийн бүтэц, мэдээлэл бүрдүүлэх, солилцох, шинэчлэх, архивлах болон ашиглахтай холбоотой нэгдсэн шаардлага, зааврыг баталж мөрдүүлэх;

3.2.3.нэгдсэн санд зөвшөөрөл, мэдэгдлийн мэдээллийг байршуулах, нийтлэх, шинэчлэх, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцаж, хяналт тавих;

3.2.4.нэгдсэн сангийн мэдээллийг хуульд заасан хүрээнд нийтэд ил тод болгох, лавлагаа, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх;

3.2.5.зөвшөөрлийн цахим хуудсанд байршуулж нийтэлсэн зөвшөөрлийн мэдээллийг шинэчлэх тохиолдолд хуучин холбоос дээрх мэдээллийг шинэчилж, өмнөх хувилбарыг цахим хэлбэрээр архивлаж, хандах боломжийг бүрдүүлэх;

3.2.6.зөвшөөрлийн цахим хуудсыг шинэчлэх, шинээр үүсгэх тохиолдолд архивласан болон байршуулж нийтэлсэн мэдээллийг огноогоор нь шинэ цахим хуудсанд хуулах, эсхүл устгахгүй байх боломжийг бүрдүүлэх;

3.2.7.нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, техникийн болон зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх.

3.3.Нэгдсэн сан, зөвшөөрөл мэдэгдлийн цахим систем хөгжүүлэгч, техникийн үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг.

3.3.1.нэгдсэн сан түүнд холбогдох цахим системд нэмэлт хөгжүүлэлтийг хийх;

3.3.2. нэгдсэн сангийн мэдээллийн өгөгдөл бүрдүүлэлт, ашиглалтад тогтмол хяналт тавих;

3.3.3.нэгдсэн санг бүрдүүлэгч талуудаас үүсгэсэн алдаатай, бүрдэл дутуу эсхүл зөрүүтэй өгөгдөл, мэдээллийг засварлуулах;

3.3.4.нэгдсэн сан, зөвшөөрлийн цахим системийн аюулгүй байдал, системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, техникийн гэмтэл, саатлыг шуурхай арилгах арга хэмжээ авах;

3.3.5.зөвшөөрөл мэдэгдлийн эрх олгох эрх бүхий этгээд болон мэдээлэл нийлүүлэгч байгууллагад системийн ашиглалттай холбоотой чиглэл, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.3.6.нэгдсэн сангийн өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийх нөхцөл боломжийг бүрдүүлж шаардлагатай тохиолдолд тайлан мэдээ гаргах;

3.3.7.нэгдсэн сангийн үйл ажиллагаанд шаардлагатай сервер, тоног төхөөрөмж, дэд бүтцийн нөөцийг жил бүр тодорхойлж, сайжруулах саналыг хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.3.8.нэгдсэн сан, зөвшөөрөл мэдэгдлийн системийн шинэчлэлт, өөрчлөлттэй холбоотой сургалт, нэвтрүүлэлтийн ажлыг зохион байгуулах.

3.4.Зөвшөөрөл олгох, мэдэгдэл бүртгэх эрх бүхий этгээдийн эрх, үүрэг.

3.4.1.зөвшөөрөл эзэмших болон сунгах өргөдлийг нэгдсэн санд бүртгэх;

3.4.2.зөвшөөрөл хүсэгчээс ирүүлсэн баримт бичгийн бүрдлийг хуульд заасан нөхцөл шаардлагын хүрээнд шалгах;

3.4.3.зөвшөөрөл хүсэгчийн өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг зөвшөөрлийн цахим системээр дамжуулан нэгдсэн санд тухай бүр шинэчлэх;

3.4.4.зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийг нэгдсэн санд бүртгүүлэх;

3.4.5.зөвшөөрлийн мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийг үндэслэл, шийдвэрийн хамт нэгдсэн санд тухай бүр шинэчлэх;

3.4.6.нэгдсэн сангийн мэдээлэлд зөрүү, алдаа илэрсэн тохиолдолд өөрийн эрх хэмжээний хүрээнд нэн даруй засварлах;

3.4.7.зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын эрхлэх асуудлын хүрээний зөвшөөрөл мэдэгдэлтэй холбоотой асуудлаар салбар байгууллага, иргэн хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгөх;

3.4.8.зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 22 дахь хэсэгт заасан хүсэлтийг энэ журмын 3.1.5-т заасан эрх бүхий этгээдийн гаргасан дүгнэлтэд үндэслэн хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор сунгана;

3.4.9.зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон болон зөвшөөрөлтэй холбоотой бусад өөрчлөлтийн мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн, байдлыг хариуцна.

3.5.Зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг.

3.5.1.нэгдсэн сангаар дамжуулан зөвшөөрөл эзэмших, сунгуулах хүсэлт гаргах;

3.5.2.өөрийн хүсэлт, шийдвэрлэлтийн явц, зөвшөөрлийн мэдээлэлтэй цахимаар танилцах;

3.5.3.нэгдсэн санд өөрийн оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хангах;

3.5.4.өөрийн зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэлд алдаа, зөрүү илэрсэн тохиолдолд зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

3.5.5.хуульд заасан тохиолдолд зөвшөөрлийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг эрх бүхий этгээдэд мэдээлэх.

3.6.Зөвшөөрөл мэдэгдэл олгож буй үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий этгээдийн эрх, үүрэг.

3.6.1.нэгдсэн санд бүртгэгдсэн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

3.6.2.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 21-т заасны дагуу зөвшөөрлийн хугацаа нь автоматаар сунгах нөхцөл бүрдсэн тохиолдолд магадлан шалгах ажиллагаа явуулахгүйгээр зөвшөөрлийг сунгах эсэх дүгнэлтийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад ажлын 2 хоногт багтаан хүргүүлэх;

3.6.3.хяналт тавих эрх бүхий этгээд нь гаргасан дүгнэлт, бүртгэсэн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах бөгөөд дүгнэлтэд өөрчлөлт орсон, эсхүл алдаатай буруу мэдээлэл бүртгэсэн тохиолдолд нэгдсэн санд нэн даруй залруулж, холбогдох байгууллагад мэдээлнэ.

3.7.Хуульд заасан үндэслэлээр нэгдсэн сангийн мэдээлэлтэй танилцах, лавлагааны мэдээлэл авах эрх бүхий этгээдийн эрх, үүрэг.

3.7.1.хуульд заасан хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгэгдсэн мэдээлэлтэй танилцах, хуульд

заасан үндэслэл, журмын дагуу холбогдох лавлагаа, мэдээллийг авч болно;

3.7.2.мэдээлэл авах эрх бүхий этгээд нь нэгдсэн санд бүртгэгдсэн мэдээллийг зөвхөн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглах бөгөөд мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, нууцлал, хувийн болон байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг хууль тогтоомжид нийцүүлэн хамгаална.

3.8.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасан мэргэжлийн нэгдсэн холбоо, эсхүл бусад хуулиар зөвшөөрөл олгох эрхийг шилжүүлж авсан хуулийн этгээд нь зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой шийдвэр гаргахдаа Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, болон энэ журамд заасан нөхцөл, шаардлагыг мөрдөж ажиллана.

3.9.Хуулиар эрх шилжүүлэгдсэн тохиолдолд зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу гаргаж, шийдвэрийг тухай бүр нэгдсэн санд мэдээлнэ.

Дөрөв. Нэгдсэн сангаас лавлагаа мэдээлэл олгох

4.1.Нэгдсэн сангаас олгох зөвшөөрлийн лавлагаа, мэдээлэл, болон мэдэгдлээр үйл ажиллагаа эрхэлж байгааг тодорхойлох баримт бичиг нь QR кодоор баталгаажсан, цахим хэлбэртэй байна.

4.2.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу зөвшөөрлийн мэдээллийг агуулсан дахин давтагдашгүй QR код бүхий баталгаажуулалтын гэрчилгээг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид цахим хэлбэрээр олгоно.

4.3.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэгдсэн сангаас QR кодоор баталгаажсан зөвшөөрөл болон лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, иргэн, хуулийн этгээд үнэ төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлнэ.

4.4.Иргэн, хуулийн этгээд нэгдсэн сангаас өөрт, эсхүл гуравдагч этгээдэд олгосон зөвшөөрөл, мэдэгдлийн лавлагааг цахим системээр дамжуулан үнэ төлбөргүй авах эрхтэй бөгөөд лавлагаанд тухайн зөвшөөрөл, мэдэгдлийн хугацаа, төлөв тодорхой тусгагдсан байна.

4.5.Нэгдсэн сангийн нууцад хамаарах мэдээлэл бүхий лавлагаа, мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, шаардлагатай тохиолдолд мэдээллийн эзэмшигчийн зөвшөөрлийн үндсэн дээр олгоно.

4.6.Мэдээлэл авах эрх бүхий этгээдийн нэгдсэн сангаас мэдээлэл харах, лавлагаа авах эрхийг тухайн байгууллагын чиг үүрэг, албан тушаалын эрх хэмжээтэй уялдуулан тогтоож, хяналтын эрхийн хүрээнд олгоно.

4.7.Нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл авах эрх бүхий этгээд нь нэгдсэн санд бүртгэгдсэн мэдээллийг өөрчлөх, устгах, нэмэх боломжгүй бөгөөд мэдээлэлд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тохиолдолд мэдээлэл бүрдүүлэгч болон сан хариуцагчид холбогдох хуулийн дагуу хүсэлт гаргана.

4.8.Хөгжүүлэгч нь нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой сургалт, цахим системийн шинчэлэлт, нэвтрүүлэлтийн ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Тав. Нэгдсэн сангийн цахим системийн орчин

5.1.Цахим системийн орчныг бүрдүүлэх

5.1.1.зөвшөөрөл, мэдэгдлийн цахим систем нь иргэн, хуулийн этгээд бизнесийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, эрсдэл багатай үйл ажиллагаа эрхлэх мэдэгдлээ эрх бүхий этгээдэд илгээх, түүний шийдвэрлэлтийн явцыг цахимаар хянах орчинг бүрдүүлнэ.

5.1.2.цахим систем нь төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын нэгдсэн сангийн ДАН систем, Зөвшөөрөл мэдэгдлийн цахим систем “license.mn”, “e-business.mn” цахим үйлчилгээ болон шаардлагатай бусад төрийн болон төрийн бус байгууллагын мэдээллийн системтэй (API) сервисээр холбогдож, мэдээлэл солилцох, нийлүүлэх боломжийг хангасан байна.

5.1.3.цахим систем нь зөвшөөрөл, мэдэгдлийн бүх шатны шийдвэрлэлтийг цахим хэлбэрээр, цаасгүйгээр гүйцэтгэх зарчимд суурилна.

5.2. Нэгдсэн сангийн үйл ажиллагаанд цахим системээр дамжуулан хандах эрх нь дараах 4 түвшинтэй байна:

5.2.1.нэгдсэн сан, цахим системийн супер админ;

5.2.2.нэгдсэн санг хөтлөх хяналтын админ;

5.2.3.нэгдсэн санг цахим системээр бүрдүүлэх байгууллагын админ;

5.2.4.байгууллагын бусад хэрэглэгч.

5.2.5.Хандах эрхийн түвшин бүрийг тухайн этгээдийн албан тушаал, чиг үүрэгт нийцүүлэн админ эрхийн тохиргоог хийх бөгөөд эрх олгох, өөрчлөх, цуцлах үйл ажиллагааг цахим системд бүртгэж, хадгална.

5.3.“Супер админ” нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1.нэгдсэн сангийн нэгдсэн удирдлага, бодлогын даалгаврыг боловсруулах;

5.3.2.нэгдсэн санд хуулиар заасан зөвшөөрөл, мэдэгдлийн ангилал, төрлөөр хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх боломжтой байхаар хөгжүүлэх саналыг Хөгжүүлэгчид нэгтгэн хүргүүлэх;

5.3.3.нэгдсэн сангийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, гарсан техникийн доголдол, саатал, алдаа, гэмтлийг бүртгэж, шаардлагатай тохиолдолд 3-5 хоногийн дотор холбогдох байгууллагад мэдэгдэж, хамтран засварлах;

5.3.4.бусад яамнаас ирүүлсэн хүсэлтийн хүрээнд системийн дүн шинжилгээ хийж, шаардлагатай хөгжүүлэлтийг тодорхойлох;

5.3.5.цахим системийн мэдээллийн аюулгүй байдал, хувийн мэдээлэл хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн шаардлагыг хангасан техникийн, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

5.4.“Хяналтын админ” нь тухайн зөвшөөрөл, мэдэгдлийн үйл ажиллагааг хянах албан тушаалтан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.4.1.нэгдсэн санд мэдээлэл шинэчлэх үйл ажиллагааг зөвшөөрөл олгох, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

5.4.2.нэгдсэн санг хөтлөх, мэдээлэл нийтлэхтэй холбогдох сургалт, нэвтрүүлэлтийн ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.4.3.зөвшөөрөл олгох, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, нэгтгэн, цахим системийн бүтцийн өөрчлөлт, хөгжүүлэлтийн бодлогын даалгаврыг боловсруулж, хөгжүүлэгчид хүргүүлэх;

5.4.4.нэгдсэн сан, түүнийг хөтлөх цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг туршиж, хэрэглээнд нэвтрүүлэх;

5.4.5.зөвшөөрөл олгох, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд үндэслэн ажлын 2 хоногт багтаан хандах эрхийн тохиргоог хийж, удирдах.

5.5.“Байгууллагын админ” болон “байгууллагын бусад хэрэглэгч”-ийн хандах эрх нь зөвшөөрөл олгох, мэдэгдэл хүлээн авах эрх бүхий этгээдэд байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1.байгууллагын админ болон байгууллагын бусад хэрэглэгчийн хандах эрх хариуцах ажилтныг томилох;

5.5.2.байгууллагын админы эрх бүхий албан хаагчийн бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүрд хяналтын админд мэдэгдэж, тохиргоо хийлгэх;

5.5.3.өөрийн байгууллага, харьяа, салбар байгууллагын холбогдох хэрэглэгчдэд цахим системийн үйл ажиллагаа, ашиглалтын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

5.5.4.байгууллагын админ нь өөрийн байгууллагын бусад хэрэглэгчийн, харьяа, салбарын хэмжээнд байгууллагын админы хандах

эрхийг удирдах, эрх авсан албан хаагчийн бүртгэлд өөрчлөлт орох бүрд шинэчлэн тохируулах;

5.5.5.байгууллагын админ нь цахим системийн үндсэн боломжийн хүрээнд тухайн олгож буй зөвшөөрлийн үйл явцтай холбоотой цэсийг байгууллагын цэсэд үүсгэх эрхтэй байх бөгөөд энэ нь цахим хуудас дахь цэс, мэдээлэлтэй давхардахгүйгээр мэдээллийг баяжуулах, бусад төрлийн системүүдтэй холбох, тохиргоо хийхэд чиглэнэ;

5.5.6.байгууллагын админ нь нэгдсэн сангийн ашиглалт, хэвийн үйл ажиллагаа, түүний сайжруулалттай холбоотой санал, хүсэлтийг харьяа байгууллагын хэмжээнд нэгтгэн яамд хүргүүлэх;

5.5.7.байгууллагын админ нь цахим системд техникийн алдаа, аюулгүй байдлын эрсдэл, саатал гарсан тохиолдолд шалтгааныг даруй тодруулж, хөгжүүлэгчид мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авах;

5.5.8.байгууллагын бусад хэрэглэгч нь нэгдсэн санд өөрийн байгууллагатай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн нийтэлж, үнэн зөв байдлыг хариуцах.

5.6.Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалт

5.6.1.Нэгдсэн санд байршуулсан хувь хүний нууцад хамаарах мэдээллийг Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаална.

5.6.2.Нэгдсэн сангийн мэдээллийн сан, сервер, тоног төхөөрөмжийг Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн хамгаална.

5.6.3.Нэгдсэн санд хандах эрх бүхий ажилтан нь мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй бөгөөд ажлын байрны нэвтрэх эрхээ бусдад дамжуулахыг хориглоно.

5.7.Системийн интеграц, өгөгдлийн уялдаа холбоо

5.7.1.Нэгдсэн сан нь Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн ХУР систем, e-Mongolia систем болон бусад төрийн мэдээллийн системтэй өгөгдлийн уялдаа холбоог хангаж, зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой төрд байгаа мэдээллийг давхардуулан шаардахгүй байх зарчмыг баримтална.

5.7.2.Нэгдсэн санд оролцогч талууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үүсгэж, бүрдүүлж, хадгалж байгаа зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой мэдээллийг нэгдсэн санд хэрэглээний програмын интерфэйс (API)-д суурилсан өгөгдөл солилцооны үйлчилгээ ашиглан цахим хэлбэрээр, шууд болон тогтоосон давтамжтайгаар нийлүүлнэ.

5.7.3.Өгөгдөл нийлүүлэгч байгууллага нь нэгдсэн санд нийлүүлж байгаа мэдээллийн үнэн зөв, бүрэн, бодит цагийн болон шинэчлэгдсэн байдлыг хариуцах бөгөөд мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлтийг API сервисээр дамжуулан нэгдсэн санд тухай бүр шинэчилнэ.

5.7.4.Цаашид нэгдсэн сан, зөвшөөрлийн системд мэдээлэл солилцооны үйлчилгээг холбохдоо техникийн нөхцөл, стандартыг нэгдсэн санг эрхлэн хөтлөх байгууллага, систем хөгжүүлэгч байгууллагатай хамтран тодорхойлно.

Зургаа.Нэгдсэн сангийн хяналт шинжилгээ, үнэлгээ, тайлан

6.1.Зөвшөөрөл олгогч эрх бүхий этгээд нь зөвшөөрөл олгох, сунгах, сэргээх, хүчингүй болгох болон зөвшөөрөл, мэдэгдэлтэй холбоотой ирүүлсэн хүсэлтийг түдгэлзүүлсэн болон татгалзсан тухай шийдвэрийг зөвшөөрөл мэдэгдлийн шийдвэрийн төлөвийг тодорхойлно.

6.2.Нэгдсэн сангийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор тус журмын 2.6-д заасан эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгож байгаа болон мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт улирал тутамд хүргүүлнэ.

6.3.Нэгдсэн сан, зөвшөөрлийн цахим системийн үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, уялдаа холбоог хангах, төрийн үйлчилгээг сайжруулах зорилгоор Яам, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн нэгдсэн холбоодын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулж, болно.

6.4.Нэгдсэн сангийн хяналт, дүн шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн давхардсан, үр ашиггүй гэж тодорхойлогдсон зөвшөөрлийн жагсаалтыг эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санал боловсруулж Зөвшөөрлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

6.5.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нэгдсэн сангийн тайлангийн нэгтгэл, мэдээг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.6.Нэгдсэн сангийн хөтлөлт, мэдээллийн шинэчлэлтэд хяналт тавихдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.19 дэх хэсэгт заасан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ыг баримтална.

Долоо.Бусад

7.1.Хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрснөөс бусад тохиолдолд хаалттай, хязгаарлалттай мэдээллийг зөвшөөрөл, мэдэгдлийн цахим системд нийтлэхийг хориглоно.

7.2.Зөвшөөрлийн цахим систем болон нэгдсэн санд хандах эрх бүхий албан хаагч нь нэвтрэх нэр, нууц үгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

7.3.Зөвшөөрлийн цахим систем болон нэгдсэн санд хандах эрхийг байгууллагын админы түвшинд устгах, сэргээх тохиолдолд хяналтын админд мэдэгдэл хүргүүлнэ.

7.4.Энэ журмыг зөрчсөн буруутай төрийн албан хаагчид хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах бөгөөд бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----o0o----